ХОВД АЙМАГ
**БИЕИЙН ТАМИР**
**СПОРТЫН ГАЗАР**

841151 Ховд аймаг, Жаргалант сум
Утас/Факс: (976) 7043-3659

2024.11.15 № 106

танай 2024.11.12-ны № 2/2024-т

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭСТ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор батлагдсан дэд хөтөлбөрийн биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар гаргаж хүргүүлэв.

Хавсралт 7 хуудастай.

ДАРГА Ч.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

ДАРГА Ч.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

ТТО8232 = 9166519

# Аймгийн ИТХ, ИТХТ-ийн тогтоолын хэрэгжилт

## Ховд аймгийн Биеийн тамир, спортын газар

## 2024 оны жилийн эцэс

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| Аймгийн ИТХ-ын тогтоол | | | | | | | |
| 1 | 1 | Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай 2020-11-24 Дугаар 2/04 | 4. 4. Сумдын Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд, орон нутгийн өмчийн газрын дарга нарт ДААЛГАХ нь: 5.1 Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан өөрийн сум, байгууллагатай холбогдол бүхий заалтуудыг хяналтад авч, хугацаанд нь хэрэгжүүлэх ажлыг бүх шатны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусган үр дүнтэй зохион байгуулж, биелэлтийг жилээр тооцон аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлж байх | Спортын секц, дугуйланд тогтмол хамрагсадын тоо Тоо суурь түвшин 6300 байсан бол 7800 болж өссөн үзүүлэлттэй байна. Иргэдийн бие бялдарын чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг жилд 2 удаа зохион байгуулдаг бөгөөд 2024.03.22-04.07 -ний хооронд зохион байгуулсан сорилд нийт 9763 иргэн хамрагдсан бөгөөд сорилын дүнг sport.gov.mn сайтад шивж оруулсан байна. сорилын 2 дахь үе 2024.11.01-12.01-ний өдрүүд ядагдаж байна. | 100% | | |
| 2 | 2 | аймгийн ИТХ-ын 2023 оны үйл | 4. Хүний нөөцийн ановчтой бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн албан | байгууллагын хүний нөөцийн бодлого болон сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан төлөвлөгөөг гарган | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх тухай 2023-12-04 Дугаар 14/02 | хаагчдын нийгмийн баталгааг хангах, мэргэшүүлэх | ажилласан. хөтөлбөрийн дагуу 1 мэргэжилтнийг Бээжинд туршлага судлуулах сургалтад , 1 мэргэжилтнийг Удирдлагын академийн чиглүүлэх сургалтад , нийт албан хаагчдийн Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтад хамруулсан байна. Мөн нийт ажилчдыг жигдэсрэн бэлтгэлийн хувцастай болгосон. Хамт олны эрүүл мэнд, уур амьсгалыг дэмжих зорилгоор 7 хоног бүрийн 3 дахь өдрийн 13.00-14.00 цагт Спорт зааландаа спортоор хичээллэж байна. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр болон дотоод журмын дагуу чөлөө тусламж хүссэн ажилтан албан хаагчдын асуудлыг тухай бүр нь шийдвэрлэж ажилласан. | | | |
| 3 | 3 | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад үнэлэлт өгөх тухай 2023-12-04 Дугаар 14/03 | 3.3. Төрийн албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, шилэн-цахим үйлчилгээг өргөжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг шинэ шатанд гаргах; | Нийт ажилчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд DELL брендийн core I7 маркийн 5 ш суурин компьютер , 4 ш 3 үйлдэлт принтерийг БТСУХ -ооноос хангасан бөгөөд бүх компьютер интернетийн сүлжээнд холбогдсон . khovd@sport.gov.mn сайтад 96 мэдээллийг оруулж shilen.gov mn-тэй холбох ажил хийгдэж байна. Үргэлжлүүлэн Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим систем болох gov.mn-д мэдээллээ байршуулахаар бэлтгэж байна. Байгууллагын paje хуудсанд 2024 онд зохион байгуулагдсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус уралдаан тэмцээн , үйл ажиллагааг тухай бүр нь оруулж байна. Албан хэрэг хөтлөлтийн Able программ ашигладаг бөгөөд Dox системд холбосноор төрийн бүх байгууллага руу албан бичиг илгээх хүлээн авах боломжтой болсон. | 100% | | |
| | 4 | | 4. Төсвийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд иргэдийн оролцоотой хөндлөнгийн хяналтыг | Биеийн тамир, спортын газрын гадна фасатыг шинэчлэх ажилд Орон нутгийн төсвөөс нийт 720 сая төгрөгөөр хийх зураг төслийг хийлгэж тендэр зарлуулахад бэлэн болсон. тендерийн үйл ажиллагаа ил тод нээлттэй зохион байгуулахад хамтран ажиллана. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тогтмолжуулж, цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж ажиллахыг сумын Засаг дарга, байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай. | | | | |
| 4 | 5 | Аймгийн 2024 оны төсөв батлах тухай 2023-12-04 Дугаар 14/04 | 11. Аймаг, сумын төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл, дүнгээр сар бүр биелүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж, зарлагын санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэн, батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээнд зориулан хэмнэлтийн горимыг баримтлан үр ашигтай зарцуулж, төсөв санхүүгийн сахилга, хариуцлагыг сайжруулан, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь заалтын дагуу төсөвт зохицуулалт хийж, өр төлбөр үүсгэхгүй, хуралдаанаар хэлэлцэх явцад гарсан санал шүүмжлэл, Хурлын дэргэдэх хороодоос оруулсан санал дүгнэлтийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга, төсвийн | 2024 онд орон нутгийн төсвөөс нийт 313.988 мян төгрөгийн санхүүжилт орж ирсэн. Санхүүжилтийг зориулалтын дагуу захиран зарцуулсан бөгөөд өр төлбөр үүсээгүй болно. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ерөнхийлөн захирагч (Э.Болормаа), төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай. | | | | |
| | 6 | | 12. Аймгийн хөгжлийн бодлого, зорилттой нийцүүлэн, оновчтой төлөвлөн батлагдаж буй “Хүүхдэд ээлтэй, хүний хөгжлийг дэмжсэн” 2024 оны аймгийн төсвийн бодлогын хэрэгжилтийг салбар бүрийн зорилттой уялдуулан үр дүнтэй зохион байгуулахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай. | Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл байгуулан эцэг эхийн зөвлөлийн ажиллах дүрэм боловсруулан батлуулж эцэг эхийн зөвлөлийн 2024-2026 оны ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу нийт ажилчдаас гэр бүл хүүхдийн судалгаа авч 0-6 настай 5 ажилтанд өглөө хүүхдүүдээ сургууль цэцэрлэгт нь хүргэж өгөх цаг гарган өгсөн . Хүүхэд , гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар, соёл, урлагийн газар, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын хорооны хамтарсан тушаалаар баталсан Соёл, спортын ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам"-ыг дасгалжуулагч нарт танилцуулсан.Хүүхдийн өрөө тохижуулах, өрөөг номын цуглуулгатай болгох ажил хийгдэж байна. мөн нийт хүүхэд багачууд, өсвөр үеийнхэнд чиглэсэн нөлөөллийн ажлууд хийгдсэн. Үүнд: Гэр бүлийн цахим хэрэглээ болон цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг хангах шторк хийж цацсан, мөн NO VAPE буюу электрон тамхины эсрэг богино хэмжээний шторкуудыг цахимаар цацсан байна. | 100% | | |
| Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол | | | | | | | |
| 5 | 7 | “Стандарттай Ховд” хөтөлбөр батлах тухай 2020-12-09 Дугаар 104 | 27.2. “Стандарттай Ховд” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвх санаачлагатай ажиллаж, чанарын менежментийн олон улсын тогтолцоог өөрийн сум, байгууллагад нэвтрүүлэх зардлыг жил бүрийн төсөвт | Дарви , Цэцэг сумын спорт заалны барилгын ажил 2020-2021 баригдаж дуусах байсан ч ковидын үе таарч материалын үнэ өссөн шалтгааны улмаас барилгын ажил түр хойшилж хугацаандаа ашиглалтад орж чадаагүй . 2023 оны орон нутгийн төсөвт Дарви сумын спорт заалны барилгын төсөв дээр 300 сая, Цэцэг сумын барилгын ажлын төсөв дээр 500 сая төгрөг тус тум нэмж суугдсан бөгөөд барилгын ажил зураг | 70% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тусган, хөтөлбөрийн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангах, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг, шуурхай байдлыг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай. | төсвийнхөө дагуу үргэлжлэн явагдаж байна. Дарви сумын барилгын ажлын гүйцэтгэл 40 хувь, Цэцэг сумын ажлын гүйцэтгэл 60 хувьтай явагдаж байгаа бөгөөд Барилгын ажлын явцыг аймгийн ГХБХБГ хянан явуулж байна. Алтай сумын Спорт заалны барилгын ажил мөн 2021 онд ашиглалтад орох байсан боловч дээрх шалтгааны улмаас хугацаандаа ашиглалтад ороогүй байгаа . 2024 онд Улсын төсвөөс 1 тэрбум төгрөг суугдсан бөгөөд ажлын явц нь 50 хувьтай үргэлжилж байна. Барилга хөгжлийн төвийн хяналтад баригдаж байгаа болно. | | | |
| 6 | 8 | Спортын аварга" дэд хөтөлбөр батлах тухай 2021-11-03 Дугаар 67 | 34. Хөтөлбөр журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулан шийдвэрлэж, хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Дүгэржав)-д үүрэг болгосугай. | 2024 онд Спортын аварга хөтөлбөр нийт 160 сая төгрөг батлагдсан . Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу спортын 8 төрлөөр Засаг даргын дэргэдэх шигшээ багт 686 тамирчин хичээллэж байна. Өсвөрийн шигшээ багийн дасгалжуулагчдын цалинд 130 сая төгрөг төсөвлөгдсөн. Аймаг орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөж медаль хүртсэн тамирчдыг урамшуулдаг " Урамшууллын журам"-ын дагуу 2024 онд амжилт гаргасан тамирчид, багш , дасгалжуулагч нарт 55 сая төгрөгийг Мөнгөн-Арслан 2024 Спортын салбарын шилдгүүдийг шалгаруулах арга хэмжээний дээр гардуулан олгохоор бэлтгэлээ хангаж байна. 2024 онд Бүс, Улсын аварга шалгаруулах тэмцээнээс нийт 372 медаль хүртсэн амжилт үзүүлсэн байна. | 100% | | |
| 7 | 9 | Цахим Ховд" дэд хөтөлбөр батлах тухай 2021-11-03 Дугаар 68 | 35.2. Хөтөлбөрийн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж хуульд заасан хугацаанд аймгийн ИТХ-ын хуралдаанд тайлагнаж ажиллахыг | тэмцээнд оролцогчдын хаяг, нас, харъяа байгууллага зэргийг тодорхойлохдоо E-mongolia системийг ашиглаж байна. khovd@sport.gov.mn сайтад 96 мэдээллийг оруулж shilen.gov mn-тэй холбох ажил хийгдэж байна. Үргэлжлүүлэн Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим систем болох gov.mn-д мэдээллээ байршуулахаар бэлтгэж байна. Байгууллагын paje хуудсанд 2024 онд зохион байгуулагдсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус уралдаан тэмцээн , үйл | 100% | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | аймгийн Засаг дарга (Б.Дүгэржав)-д даалгасугай. | ажиллагааг тухай бүр нь оруулж байна. Албан хэрэг хөтлөлтийн Able программ ашигладаг бөгөөд Dox системд холбосноор төрийн бүх байгууллага руу албан бичиг илгээх хүлээн авах боломжтой болсон. | | | |
| 8 | 10 | “Хариуцлагатай тунгалаг төр” аймгийн дэд хөтөлбөр батлах тухай 2021-12-22 Дугаар 161 | 2. 3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхи санаачилгатай ажиллаж, хөтөлбөрийн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангах, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай. | Газрын даргын 2023.01.06-ний өдрийн А/05 дугаар тушаалаар Байгууллагын "Ёс зүйн зөвлөл"-ийг шинэчлэн байгуулсан. 2024 оны тухайд Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байгүй. Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулиар нийт ажилчдад Аймгийн захиргааны хэргийн шүүгч М.Мянганбаяр сургалт явуулсан. Ховд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг спорт клубуудын үйл ажиллагааг тогтмолжуулах үйл ажиллагааг нь дэмжиж арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж байна. спортын барилга байгууламжуудад тооллого явуулж үйл ажиллагааг нь жигдрүүлэн. Сум бүрт орон тооны арга зүйчтэй болох саналаа холбогдох газарт нь уламжилсан. | 100% | | | |
| 9 | 11 | “Дугуйтай Ховд” дэд хөтөлбөр батлах тухай 2021-12-30 Дугаар 172 | 1. 2.Аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д ҮҮРЭГ БОЛГОХ нь: 2.1.“Дугуйтай Ховд” аймгийн дэд хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан, холбогдох байгууллагуудын салбар дундын бодлого зохицуулалтыг удирдлага зохион байгуулалтаар хангаж иргэд, Төрийн бус байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэн ажиллах. | Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудтай уулзаж ажилтан албан хаагчдаа дугуйн хэрэглээг тогтмол хэвшүүлэх санал тавьж хамтран ажилласан. Эв нэгдэл спортоор манлайлья аяны хүрээнд Дугуйн аялал зохион байгуулсан. | 100% | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | 12 | “Дугуйтай Ховд” дэд хөтөлбөр батлах тухай 2021-12-30 Дугаар 172 | 2. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөв болон гадаадын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн байгууллагуудын санхүүжилтэд тусгаж хэрэгжүүлэх. | Төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагууд, аймгийн дугуйн холбоо , БТСГ хамтран дугуйн аялалуудыг зохион байгуулж ажилласан. | 100% | | |